

**ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН МАТЕРИАЛ**

Хүчтэй. Хамтдаа.

## ХУРЛЫН МАТЕРИАЛЫН АГУУЛГА

|                                                                                               |    |
|-----------------------------------------------------------------------------------------------|----|
| Гүйцэтгэх захирлын мэндчилгээ                                                                 | 4  |
| Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг                                                               | 11 |
| Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол       | 12 |
| Хурлаар хэлэлцэх асуудал                                                                      | 14 |
| Хурлын зар                                                                                    | 18 |
| Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материал                                                | 20 |
| 2018 оны жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлт | 20 |
| 2018 оны санхүүгийн тайлан                                                                    | 23 |
| Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга        | 29 |
| Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл                                            | 41 |

## **АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ХҮРГЭХ МЭНДЧИЛГЭЭ**

Ардын эрхэм хувьцаа эзэмшигч, Та сайн байна уу?

Улиран одсон 2018 онд бид олон жил бэлтгэсэн ажлын үр дүнг тооцож, огцом өсөлтийг хангах сууриа эцэслэн тавьсан жил боллоо. Юуны түрүүнд бидэнд итгэж, бидэнтэй хамт байсан танд гүн талархал илэрхийлж, танд болон танай гэр бүл, хамт олонд хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе!

Бидний та бүгдэд байнга сануулж ирсэн нэг зүйл бол хөрөнгө оруулалт хийнэ гэдэг нь асар их итгэл болон хариуцлагын асуудал мөн. Компанийн хувьцааг авна гэдэг нь тухайн компанийн үйл ажиллагаа, удирдлага, бүтээгдэхүүн, үзэл санаанд итгэх, түүнийг дэмжих дээд хэлбэр гэж бид хардгаа. Тэрхүү итгэлийн нэг хэмжүүр нь компанийн хувьцааны эрэлт, түүнийг дагасан үнэ өөрөө байдаг. Хувьцааг өсч байхад нь аваад, унаж байхад зараад богино хугацаанд ашиг хонжоо хийхээс аль болох зайлсхийх хэрэгтэй гэдгийг бид ямагт сануулдгаа. Алдаа хийж, алдагдалд орох магадлал тун өндөр учраас. Тийм ч учраас бид урт хугацаанд үнэ цэнийг бий болгох хөрөнгө оруулалтыг эрэлхийлэн хийж, бүхий л анхаарлаа зөвхөн түүнд төвлөрүүлэн ажилладаг билээ. Та бүхэн ч биднээс тийм л зүйлийг хүлээгээсэй гэж бид хүсдэг.

Өнөөдөр Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцааны дотоод үнэлгээ 3,000 төгрөгөөс давж, хаалттай хэлбэрээр арилжаа явагдсаар байна. Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа эзэмшигчид 3 мянгуулаа боллоо. Монголын Хөрөнгийн Биржээс бидэнтэй нэгдэхийг зөвшөөрсөн Жинст Увс (JIV) буюу Хөрөнгө Оруулагч Үндэстний хувьцааны хаалтын ханш 2,341 төгрөгт хүрэв. 2016 онд бид мянгуулаа цугларч, хөрөнгөө нийлүүлж, Хөрөнгө Оруулагч Үндэстэн гэх хөдөлгөөнийг эхлүүлж байсан бол бидний анхны хөрөнгө оруулалт 130 хувиар өссөн байна. Энэ бол чамгүй сайн үзүүлэлт гэж би бодож байна. Та ч санал

нийлэх байхаа. Бидэнд итгэж, бидний үйл хэргийг дэмжиж, ямагт тэвчээр заан хамт байсан та бүхэндээ би талархаж, мэхийн ёслоё!

Ард Даатгалын IPO амжилттай явагдаж, үндэстнээрээ хөрөнгө оруулагч болох хөдөлгөөн илүү хурдацтай, далайцтай өрнөж эхэлсэн бол Ард Кредит олон нийтэд хувьцаагаа гаргах шалгуураа хангаж, СЗХ болон МХБ-ээс зөвшөөрлөө авахаар хүсэлтээ гарган зөвшөөрүүлсэн амжилтаар бид 2018 оныг үдлээ. МХБ дээр арилжаалагдаж байгаа манай JIV болон MNP хувьцаа тогтвортой үнэлгээтэй явж ирсэн бол Ард Санхүүгийн Нэгдэл маань өөрөө JIV-тэй нэгдэх байдлаар олон нийтэд нээлттэйгээр хувьцаагаа арилжаалах боломж нээгдэхийг бид тэсэн ядан хүлээж байна. 2018 оны 12 дугаар сарын сүүлээр бидний зөвшөөрөл Монголын Хөрөнгийн Биржээс гарч, СЗХ-ны шийдвэрийг хүлээх үдлээ. 2019 онд Ард Даатгал, Ард Кредит, Монгол Шуудан хувьцаат компаниудад хөрөнгө оруулалттай, нийт ард иргэддээ хувьцаагаа нээлттэй арилжаалдаг анхны санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэгч финтек нэгдэл болох шалгуурыг бид бүрэн хангаж чадлаа гэж дүгнэж байна.

Мэдээжийн хэрэг хувьцаагаа хөрөнгийн бирж дээр гаргахаар л өсөөд байна гэсэн баталгаа байхгүй. Миний удирдаж буй баг 2018 онд таны бидэнд итгэж даалгасан хөрөнгө оруулалтын үнэ цэнийг урт удаан хугацаанд өндөр өсөлттэй байлгах зорилготой ажил санаачлагыг олноор эхлүүлсэн жил боллоо. 2019 оны 1 дүгээр сард бид "Ардын Түрийвч" болох Ард Аппын нээлтийг хийж, ард түмэндээ "Ардын Дэлгүүр"-ийн үйл ажиллагааг танилцууллаа. Тиймээ, бид цогц санхүүгийн үйлчилгээг нэг дороос танд хүргээд зогсохгүй амьдралын бүхий л хэрэгцээтэй эд зүйл, үйлчилгээг танайд хүргэх гэсэн зорилгодоо бүрэн дүүрэн хүрч чадлаа.

2018 оны 4 сард бид ГоүПэй гэх биткойны анхдагч хэтэвчийг танилцуулсан бол өнөөдөр 2 дахь хувилбарыг таны гар дээр тавилаа.

Ард Кредит Монгол Шуудантай хамтран гадаад гуйвуулга, барьцаагүй зээлийн үйлчилгээг нэвтрүүлэхээр бэлтгэл ажлаа базаан туршиж эхэлсэн бол Ард Шопын хүргэлтийг Монгол Шуудан дангаараа хариуцан ажиллаж эхэллээ. Бид туршилтын байдлаар хамтарсан салбараа байгуулсан бол төрийн үйлчилгээг хөдөөд хүргэх ажлыг Монгол Шуудан холбогдох байгууллагуудтай хамтран эхлүүлээд байна. Монгол Шуудан бол Монголдоо төдийгүй дэлхийд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа ямар төвшинд явж болохын тод жишээ болж чадсан.

2019 онд бид өөрийн хэрэглэгчиддээ онлайн арилжааны боломжийг нээж өгөхөөр мэдээллийн технологийн түншүүдтэйгээ хамтран туршилтуудыг амжилттай явуулан зах зээлд нэвтрүүлж эхлэв.

Ингэснээр бид 2020 оны бизнес төлөвлөгөөндөө заасан олон нийтийн өмчийн дижитал банк болно гэсэн зорилгодоо хүрэх болзлыг бүрэн хангах боломжтой болж байна. Таны гар дээр очсон энэхүү тайланд компанийн хийж гүйцэтгэсэн ажил, санаачлага, хөрөнгө оруулалт, түүний өгөөж, манай санхүүгийн эх үүсвэр, түүний зарцуулалт, хувьцаа эзэмшигчдийн өгөөж, хувьцааны үнэ цэнэ, ер нь таны хөрөнгө оруулсан компанийн үйл ажиллагаа хэрхэн явж байгаа талаар өгүүлэх болно.

Ард Санхүүгийн Нэгдлийн Гүйцэтгэх Захирлын зүгээс 2019 оны эхний өдөр өнгөрсөн жилийн гол үйл явдлуудыг нэгтгэж та бүхэндээ Фэйсбүүк хуудсаараа хүргэснийг та хүлээн авсан байх. Энд дахин нэг сийрүүлье.

Хоосон газар хувьцааны үнэ өсөхгүй, итгэл бий болохгүй – бид хэлснээ хийсээр ирснийг та бүхэн харсан. Тэгвэл бид таны хөрөнгийг хэрхэн удирдаж, ирээдүйд үнэ цэнийг өсгөх ямар ажил үйлчилгээг санаачилсныг доорхоос сонирхоно уу. Бид амласан ёсоороо Ард Даатгалын IPO-г хийж, компанийнхаа 30 хувийг 5.3 тэрбум төгрөгөөр олон нийтэд санал болгосон. Үүний үр дүнд Ард Даатгал хамгийн олон хүний өмчийн даатгалын компани болж чадсан. Тиймээ, бид одоо 1,500-уулаа боллоо. Мэргэжлийн байгууллагуудын хийсэн үнэлгээ 1,200 гаруй төгрөгөөр тогтсон ч AIC 2018 онд 770 төгрөгөөр хаагдсан нь цаашид ч энд боломж агуулагдсаар байгааг илтгэнэ. 770 төгрөгийн ханш нь Ард Санхүүгийн Нэгдлийн үнэлгээнд эерэг 3.3 тэрбум төгрөгийн нөлөөлөл авчирлаа. Ард Даатгал үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөж, 2018 онд хамгийн өндөр хураамжийн орлого, хөрөнгө оруулалтын орлого бүрэлдүүлж чадсан юм. 2019 онд Ард Даатгал үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ой тохиож байна. Бид энэ ойгоо ажил хөдөлмөрийн өндөр амжилтаар угтаж, та бүгдтэйгээ хамт тэмдэглэхээр зэхэж байна. Бид даатгалын үйлчилгээг танд цахимаар ойртуулж, хүртээмжийг улам нэмэгдүүлж, зах зээлд ашиг орлогоороо манлайлах зорилго дэвшүүлж байгаа. Та дэмжээрэй!

Бид оны дундуур Монгол Шуудангийн 3.6 хувийг худалдсан боловч компанийн хувьцааны үнэ 684.03 төгрөгт хүрч хаагдсан. Монгол Шуудангийн үйл ажиллагаа жигд өсөн дэвшиж, шинэчлэгдэн өргөжиж байгаад бид сэтгэл хангалуун байгаа. Цахим худалдаа Монголд газар авч, бараа, бүтээгдэхүүний хүргэлтийн үйлчилгээний орлого огцом өсөн банк санхүүгийн үйлчилгээг шуудангийн салбараар явуулснаар орлогын шинэ нэр төрөл орж ирнэ гэж бид тооцоолж байгаа. Төрийн үйлчилгээг цахимаар хүргэх ажилд Монгол Шуудан хүчин зүтгэхээр болж, улсаас тодорхой хэмжээний төсөв мөнгө батлагдсан нь Монгол Шуудангийн шинэчлэлийн ажилд түлхэц болно гэж бид харж

байгаа. Цаашид Монгол Шуудангийн хувьчлал Монголын Хөрөнгийн Биржээр үргэлжлэн явагдаж, та бид хамтдаа илүү их хувийг хамтдаа эзэмших боломж нээгдэнэ гэдэгт би итгэлтэй байна.

Ард Кредит бол манай цахим банкны стратегийн цөм болсоор явж ирсэн. 2018 онд бид цахим банкаа босгож чадсан – яг нэг жилийн өмнө Грэйп Сити болон Мост Монитой стратегийн түншлэлийн гэрээ байгуулж, Ардын цахим түрийвчийг нэвтрүүлж, банкны төлбөр тооцоо хийж эхэлсэн бол 2019 оны 1 сард бид Ард Аппын 2 дугаар хувилбарыг та бүхэндээ танилцуулах болно. Ард Апп нь уламжлалт банкны үйлчилгээ болох хадгаламж, зээл, төлбөр тооцоо хийхээс гадна хөрөнгийн биржийн арилжаанд оролцох, гадаад валют авах, зарах, даатгалын үйлчилгээнд хамрагдах, крипто-валютаар гүйлгээ хийх, хувийн тэтгэврийн хуримтлалаа удирдах зэрэг боломжийг олгоод зогсохгүй та гэрээсээ гаралгүй дэлгүүрээсээ бараагаа захиалан авчруулах боломжийг олгох юм. Монголд анх удаа та банкны салбар дээр очилгүй хиймэл оюуны тусламжтайгаар зээлээ авах болж байгаагаараа Ард Апп давуу талтай.

Ард Кредитийн IPO хийх зөвшөөрөл гарснаар бидний олон жил мөрөөдөж, ярьж, зүтгэсэн олон нийтийн эзэмшлийн банк мэндлэх болно. Энэ бол бидний хамтын уйгагүй хөдөлмөрийн үр дүн юм. Одоо түүнийг барьж үзэх л үлдлээ.

Ард Секюритизын үйл ажиллагаа тогтворжиж, хөрөнгийн зах зээлийн хамгийн идэвхтэй оролцогч болоод зогсохгүй хамгийн олноор шинээр харилцагч татаж ажиллаж эхэллээ. Бид та бүхэндээ цахимаар хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцох боломжийг нээж өгч чадлаа. Хөрөнгө оруулалтын судалгаан дээр тулгуурласан таны хамгийн найдвартай зөвлөх болон хамгийн чанартай IPO, бонд гаргадаг компани болох болзлыг бид хангаж чадлаа гэж үзэж байгаа.

Ард Активын хөрөнгө нугаран өсч, Ард Лайф үйл ажиллагаагаа тэлсээр байна. Ард Менежмент хувьчлалын сан босгох ажлаа үргэлжлүүлэн КристоҮндэстэн болон манай үл хөдлөх хөрөнгийн сангуудыг удирдаж ирлээ.

АрдБитын хувьд 2019 оноос эхлэн үйл ажиллагаагаа идэвхжүүлж, Ард Санхүүгийн Нэгдлийн анхны лоялти хөтөлбөрийг гардан удирдахаар болж байгаа. 2019 оны 1 сард таны гар дээрх АрдКойн эргэлтэнд орох болно.

Та анх манайд хөрөнгө оруулахдаа дэлгүүртэй болно гэж санаагүй байх. Тэгвэл бид танд хил хязгааргүй дэлгүүр болох АрдШопыг танилцуулахад таатай байна. Одооноос эхлээд таны авах гэж байгаа бараа чинь энэ дэлхийн хаана ч байж болно. Та түүнийг АрдШопоос захиалахад бид таны байгаа газар чинь хүргэж өгөх болно.

Хүчтэй, Хамтдаа гэж бид зүгээр л хэлж ярьдаг зүйл огт бишээ: Ард Санхүүгийн Нэгдэл Грэйп Сити, АйСиТи Групп, Мост Мони ПСП, Трассчэйн гэх зэрэг компаниудтай хамтран ажиллаж ирсэн бол ГоүПэй крипто түрийвч, Дижитал Эксченж Монголия, ЭМИСи Партнерс компаниудад стратегийн хөрөнгө оруулалтуудыг та бүхний өмнөөс хийлээ.

Бид 2018 ондоо багтан Ард Риалти, Ард Пропертиз, Ард Лизинг гэх шинэ компаниудыг үүсгэн байгуулж, Ардын ам бүлд нэмлээ.

Таны хөрөнгөө оруулсан компанийн хувьд 2018 он бүхэлдээ амжилттай өрнөж, өндөрлөлөө. Бидний тооцоолж байгаагаар зөвхөн Ард Кредит, Ард Даатгал, Монгол Шуудангийн нөлөөллөөр манай нэг хувьцааны дотоод үнэлгээ 2019 онд 4 мянган төгрөгийг давах төлөвтэй байгаа болно. Харин миний дээр дурдсан бусад компани, санаачлага, төслийн үр дүн, тэдгээрийн амжилт үүн дээр

нэмэгдэж тооцогдохыг болгооно биз ээ? Таны мөнгө таны төлөө зогсолтгүй ажилласаар байгаа болно. Эхний үр дүн ч сайн байгаад бид сэтгэл өндөр, урам зоригтой байгаа.

Үүгээр би гүйцэтгэлийн тоймоо товчлон өндөрлөө. Та энэхүү тайлангаас санхүүгийн гүйцэтгэл, боловсон хүчний бодлого, технологийн дэвшил, шинэ хөрөнгө оруулалт, үнэлгээ, манай хувьцаа эзэмшигчдийн бүтцэд гарсан өөрчлөлт, Төлөөлөн Удирдах Зөвлөл, дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын талаар бидний хийсэн ажлын талаар мэдээлэл авах болно. Таны хөрөнгө оруулалтын мэлмий ямагт саруул байх болтугай! Шинээр гарч буй 2019 он Монголчуудын хувьд олз омог ихийг ивээх болтугай!

Хүчтэй. Хамтдаа!

Ч.Ганхуяг  
Гүйцэтгэх захирал

## АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хурал 2019 оны 4-р сарын 27-ны өдрийн  
14:00 цагт эхэлж, 16:00 цагт дуусна

|                                                                                                                      |             |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|
| Хуралд оролцогчдыг бүртгэх                                                                                           | 14:00-14:10 |
| Бүртгэлийн ажиллагааны дүнг гаргах                                                                                   | 14:10-14:20 |
| Хурлыг нээх                                                                                                          | 14:20-14:30 |
| 2018 оны санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн<br>тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг<br>батлах | 14:30-14:50 |
| Асуулт, хариулт, санал хураалт                                                                                       | 14:50-15:00 |
| Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус<br>гишүүдийг танилцуулах, сонгох                                  | 15:00-15:20 |
| Асуулт, хариулт, санал хураалт                                                                                       | 15:20-15:30 |
| Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах                                                                    | 15:30-15:50 |
| Хурлаас гарсан шийдвэрийг Хурлын дарга танилцуулж,<br>хурлыг хаах                                                    | 15:50-16:00 |

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг  
Жич: Шаардлагатай бол Хурлын хугацааг сунгаж болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2,  
Ард Холдингс ХК-ийн байр, 2 давхарт, w3w: цэнэг.ардэмтэй.өнгөлөх,  
Утас: 77078080, 11-321899, Цахим хаяг: info@ardholdings.com

2019 он 03 сар 18 өдөр

Дугаар 19/06

Улаанбаатар хот

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал  
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн эцнээ санал хураалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2019 оны 4 сарын 27-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Дүнжингаравын 14-р гудамж Зайсан Хилл Комплекс зарлан хуралдуулсугай.
2. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 4 сарын 11-ний өдрөөр тогтоосугай.
3. Хурлыг зарыг 2019 оны 3 сарын 22-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу өдөр тутмын сонингоор дамжуулан нийтэд мэдээлсүгэй.
4. Хурлын даргаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг томилсугай.
5. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Хууль, дүрмийн хэрэгжилт хариуцсан захирал С.Халиунаа;  
Маркетинг хариуцсан захирал Ц.Должин;  
Санхүү эрхэлсэн захирал Б.Золбоо;

Ерөнхий нягтлан бодогч Г.Сэлэнгэ;

Компанийн нарийн бичгийн дарга А.Батболд;

6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2019 оны 4 сарын 26-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.

8. Дахин мэдээлэх хугацааг 2019 оны 4 сарын 6-ны өдрөөр тогтоосугай. Анх зарласан хэвлэл мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигч, олон нийтэд хүргэсүгэй.

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.

Үүнд:

Тооллогын комиссын дарга:

Өмгөөллийн И ЭЛ СИ ХХН-ийн өмгөөлөгч Х.Баасанжаргал

Тооллогын комиссын гишүүд:

Өмгөөллийн И ЭЛ СИ ХХН-ийн хуульч С.Батчимэг

Өмгөөллийн И ЭЛ СИ ХХН-ийн хуульч Х.Оюун-Эрдэнэ

10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Ганхуягт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2019 оны 3-р сарын 18-ны өдрийн  
19/06 тоот тогтоолын 1-р хавсралт

**2019 ОНЫ 4-Р САРЫН 27-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ  
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;
2. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох тухай.

**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК САНАЛ АВАХ ХУУДАС**  
**(Хэлэлцэх асуудал №1)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: \_\_\_\_\_  
Регистрийн дугаар: \_\_\_\_\_  
Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн  
Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

Энэхүү санал авах хуудсаар 2019 оны 4 сарын 27-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Дүнжингаравын 14-р гудамж Зайсан Хилл Комплекс хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

| № | Хурлаас гарах<br>шийдвэрийн томьёолол                                                                                                                    | Зөвшөөрсөн               | Татгалзсан               | Түдгэлзсэн               |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|
| 1 | Ард Санхүүгийн Нэгдэл<br>ХК-ийн 2018 оны үйл<br>ажиллагааны болон<br>санхүүгийн тайланд Төлөөлөн<br>удирдах зөвлөлийн гаргасан<br>дүгнэлтийг баталсугай. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Завсарласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.
5. Саналыг саналын хуудсаар эсвэл цахимаар өгөх боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг \_\_\_\_\_  
Санал авах хуудсыг үйлдсэн 2019 оны .. сарын .. өдөр  
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй  
Тооллогын комиссын дарга \_\_\_\_\_/...../  
Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК САНАЛ АВАХ ХУУДАС**  
**(Хэлэлцэх асуудал №2)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: \_\_\_\_\_

Регистрийн дугаар: \_\_\_\_\_

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

Энэхүү санал авах хуудсаар 2019 оны 4-р сарын 27-ны өдрийн 14:00 цагт цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Дүнжингаравын 14-р гудамж Зайсан Хилл Комплекс хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

| №                 | ТУЗ-ийн гишүүнд нэр<br>дэвшигчдийн нэрс | Нэр дэвшигчид өгөх<br>саналын тоо |
|-------------------|-----------------------------------------|-----------------------------------|
| Ердийн гишүүн     |                                         |                                   |
| 1                 | Чулуун овогтой Ганхуяг                  |                                   |
| 2                 | Хишигдорж овогтой Батхишиг              |                                   |
| 3                 | Авир овогтой Сүхдорж                    |                                   |
| 4                 | Бруно Рашле                             |                                   |
| 5                 | Одончимэд овогтой Одбаяр                |                                   |
| 6                 |                                         |                                   |
| 7                 |                                         |                                   |
| Хараат бус гишүүн |                                         |                                   |
| 1                 | Пүрэвжаргал овогтой Батбаяр             |                                   |
| 2                 | Мөнх-Очир овогтой Сэргэлэн              |                                   |
| 3                 | Чулуун овогтой Мөнхбат                  |                                   |
| 4                 | Жим Андерсон                            |                                   |
| 5                 | Михаил Зелдович                         |                                   |
| 6                 |                                         |                                   |

Санамж: ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 10 гишүүнтэй байхад үүнээс 5 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 1000 саналын эрхтэй ( $100 \times 10 \text{ гишүүн} = 1000$ ) болох бөгөөд үүнээс 500 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 5 хүртэл нэр дэвшигчид, 500 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 5 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна. Саналыг саналын хуудсаар эсвэл цахимаар өгөх боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг \_\_\_\_\_/...../  
Санал авах хуудсыг үйлдсэн 2019 оны ...сарын ...-ны өдөр  
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх:  
Тооллогын комиссын дарга \_\_\_\_\_/...../  
Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

### Санал өгөх зааварчилгаа:

Хувьцаа эзэмшигч та саналаа саналын хуудсаар болон ухаалаг утас ашиглан цахимаар өгөх боломжтой. Хэрвээ та цахимаар саналаа өгөх бол хурлын өдөр БҮРТГЭЛИЙН ХЭСЭГ дээр очиж нэвтрэх нэр болон нууц кодоо аван саналаа өгнө үү!

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2019 оны 3-р сарын 18-ны өдрийн  
19/06 тоот тогтоолын Хавсралт №3

## **АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Дүнжингаравын 14-р гудамж Зайсан Хилл Комплекс болох тул хувьцаа эзэмшигчид Та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай;
2. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох тухай;
3. Бусад асуудал;

Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь:  
**2019 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр** байна.

**Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:**

1. 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл;

Хувьцаа эзэмшигч Та бүхэн хуралдаа итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцож болох ба брокер дилерийн компаниудаар дамжуулан санал авах хуудсаар саналаа урьдчилж өгөх боломжтой. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацаа 2019 оны 4 сарын 26-ны өдрийн 14:00 цагт дуусна.

Мөн Та бүхэн 2019 оны 4 сарын 27-ны өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 9:00-18:00 цагийн хооронд Ард Секюритиз ҮЦК ХХК-ийн Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдлийн байр, 2 давхар хаягаар ирж хурлын материалтай танилцах боломжтой.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд ирж болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбоо барьж авна уу.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдлийн байр, 2 давхар Утас: 77078080, 88858983  
Имэйл хаяг: [info@ardholdings.com](mailto:info@ardholdings.com), [zolzaya.j@ardsecurities.com](mailto:zolzaya.j@ardsecurities.com)

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ийн  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА,  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ГАРГАСАН ДҮГНЭЛТ**

2018 он Ард Санхүүгийн Нэгдлийн хувьд өргөн тэлэх, үйл ажиллагаагаа сайжруулах, хувьцаа эзэмшигчдийн тоогоо нэмэгдүүлсэн сайхан жил болж өнгөрлөө. Хөрөнгө оруулалт хийсэн Монгол Шуудан ХК-тай хамтарсан салбараа Централ Тауэрт нээлээ. Мөн хөдөө орон нутагт анхны Ардын Эрдэнэт салбар байгуулагдлаа. Салбар байгуулагдсанаар хувьцаа эзэмшигчид болон харилцагч нартаа тогтмол мэдээлэл түгээх, хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэх боломжууд гарч ирж байна. 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаа 4 сарын 27-ны өдөр зохион байгуулж, Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй Жинст Увс ХК-тай нэгдэх шийдвэр гаргалаа. 2018 оны 12 сарын 27-ны өдөр Монголын хөрөнгийн биржээс биднийг нэгдэх зөвшөөрлийг авч, Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэрийг тэсэн ядан хүлээж байна. Энэхүү шийдвэрийн дагуу бид тун удахгүй 2019 ондоо багтан Монголын Хөрөнгийн Бирж дээр гарч, томоохон тоглогч болно гэдэгтээ итгэлтэй байна. Хүүхдэд зориулан урт хугацааны хөрөнгө оруулалт хийх нь хамгийн тохиромжтой бөгөөд санхүү, хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүнээс өгөөж хамгийн өндөр байх боломжтой нь хувьцаа юм. Иймд Ард Санхүүгийн Нэгдэл нь Хувьцаатай хүүхэд хөтөлбөрийг санаачилж, ирээдүй болсон бяцхан үрсдээ зориулан урт хугацааны хөрөнгө оруулалт хийхийг уриалж эхэллээ. Тус аяны хүрээнд 2018 онд бид нэмж 510 хувьцаа эзэмшигчээр эгнээгээ өргөжүүлээд байна.

2018 онд Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө 60.46 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 21.75 хувиар буюу 10.81 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтийн гол хүчин зүйл нь бидний хөрөнгө оруулалтын багцын дахин үнэлгээний өсөлт болох 4.78 тэрбум төгрөг байсан. Мөн авлага болон бусдад олгосон зээлийн багц 2.55 тэрбум төгрөгөөр, борлуулах зорилгоор эзэмшиж буй болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө 3.59 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Мөн энэхүү хөрөнгийн өсөлтийн санхүүжилтийг 3.41 тэрбум төгрөгийн өр төлбөрөөр, 7.40 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгийн өсөлтөөр бүрдүүлсэн байна.

Өөрийн хөрөнгө буюу эздийн өмч 43.11 тэрбум төгрөгөөс 17.16 хувиар буюу 7.40 тэрбум төгрөгөөр өсч, 50.51 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2018 онд нийт үйл ажиллагааны орлого 3.68 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 752.39 сая төгрөгөөр буюу 25.60 хувиар өссөн байна. Бид Ард Даатгал, Ард

Кредит болон Монгол Шуудан зэрэг компаниудаас нийтдээ 897.65 сая төгрөгийн ногдол ашгийг хүлээн авсан бөгөөд энэ нь өмнөх жилийн ногдол ашгийн орлогоос 540.80 сая төгрөгөөр их байв. Мөн бидний үйл ажиллагаа өргөжиж, олон нийтэд хүрч ажиллах цар хүрээ нэмэгдэж, санхүүгийн эх үүсвэрийн зардал нэмэгдсэнтэй холбоотойгоор нийт зардал 2.73 тэрбум төгрөгөөс 4.49 тэрбум төгрөг болж өссөн.

Тайлант жилд бид үйл ажиллагаанаасаа 667 сая төгрөгийн цэвэр ашгийг үйлдвэрлэсэн бөгөөд хөрөнгө оруулалтын үнэ цэнийн цэвэр өсөлтөөс 6.73 тэрбум төгрөгийг үүсгэснээр нийт 7.40 тэрбум төгрөгийн нийт ашигтай ажилласан байна. Энэ нь 2017 оны нийт ашиг болох 5.67 тэрбум төгрөгөөс 1.73 тэрбум төгрөгөөр буюу 30.51 хувиар их байгаа юм.

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| Үзүүлэлт                                                 | 2018.12.31<br>мянган төгрөг | 2017.12.31<br>мянган төгрөг |
|----------------------------------------------------------|-----------------------------|-----------------------------|
| <b>ХӨРӨНГӨ</b>                                           |                             |                             |
| <b>Эргэлтийн хөрөнгө</b>                                 |                             |                             |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө                           | 2,034.8                     | 689,066.4                   |
| Дансны авлага                                            | 2,637,355.8                 | 4,622,143.4                 |
| Татвар, шимтгэлийн авлага                                | 14,941.4                    | 14,726.0                    |
| Бусад авлага                                             | 7,184,324.4                 | 2,647,746.1                 |
| Бараа материал                                           | 36,364.2                    | 23,175.5                    |
| Урьдчилж төлсөн зардал                                   | 830,472.1                   | 423,914.0                   |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт                         | 146,055.7                   | 107,604.6                   |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй<br>эргэлтийн бус хөрөнгө | 2,400,000.0                 | 1,220,000.0                 |
| <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>                           | <b>13,251,548.4</b>         | <b>9,748,376.1</b>          |
| <b>Эргэлтийн бус хөрөнгө</b>                             |                             |                             |
| Үндсэн хөрөнгө (цэвэр)                                   | 739,940.7                   | 627,821.1                   |
| Биет бус хөрөнгө (цэвэр)                                 | 246,604.6                   | 246,216.5                   |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт                            | 43,810,718.8                | 39,033,912.7                |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл<br>хөдлөх хөрөнгө     | 2,417,832.1                 |                             |
| <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>                       | <b>47,215,096.2</b>         | <b>39,907,950.3</b>         |
| <b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>                                      | <b>60,466,644.6</b>         | <b>49,656,326.3</b>         |
| <b>ӨР ТӨЛБӨР</b>                                         |                             |                             |
| <b>Богино хугацаат өр төлбөр</b>                         |                             |                             |
| Худалдааны болон худалдааны бус өр<br>төлбөр             | 131,267.0                   | 1,173,215.0                 |
| Цалингийн өглөг                                          | -                           | 34.6                        |
| Бусад өглөг                                              | 12,675.8                    | 69,726.7                    |
| Банкны богино хугацаат зээл                              | 1,814,620.0                 | 1,080,072.9                 |
| Зээлийн хүүний өглөг                                     | 251,491.3                   | 57,743.9                    |
| Татварын өглөг                                           | 23,831.0                    | 67,354.4                    |
| ЭМ НДШ-ийн өглөг                                         | -                           |                             |
| Урьдчилж орсон орлого                                    | -                           | 22,032.0                    |
| <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>                  | <b>2,233,885.1</b>          | <b>2,470,179.5</b>          |
| <b>Урт хугацаат өр төлбөр</b>                            |                             |                             |
| Урт хугацаат зээл                                        | 240,370.2                   |                             |
| Бусад урт хугацаат өр төлбөр                             | 5,524,671.1                 | 2,781,782.5                 |
| Хойшлогдсон татварын өглөг                               | 1,957,039.5                 | 1,292,210.5                 |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн                            | 7,722,080.8                 | 4,073,993.0                 |
| <b>Нийт өр төлбөр</b>                                    | <b>9,955,965.9</b>          | <b>6,544,172.5</b>          |

| Үзүүлэлт                                       | 2018.12.31<br>мянган төгрөг | 2017.12.31<br>мянган төгрөг |
|------------------------------------------------|-----------------------------|-----------------------------|
| <b>Өөрийн хөрөнгө</b>                          |                             |                             |
| Энгийн хувьцаа                                 | 1,879,652.8                 | 1,879,652.8                 |
